



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/202

Мандалговь

Ланд овнер ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй “Дэрэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулах ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Ланд овнер” ХХК-тай 94,600,000 (ерэн дөрвөн сая зургаан зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан техникийн тодорхойлолтын дагуу “Дэрэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулах ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Ланд овнер” ХХК-ийн захирал (Г.Гантулга)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга (Н.Түвшинжаргал) Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4872150448